



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/МД

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын гимнастикийн холбооноос ирүүлсэн хамтран ажиллах хүсэлтийн дагуу 2015 оны Улсын аварга шалгаруулах спорт аэробикийн тэмцээнийг 06 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд зохион байгуулсугай.

2. Спорт аэробикийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ж.Ганболд-Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүдэд: Л.Дамдинсүрэн-Эрүүл мэндийн газрын дарга, Монгол улсын хүний гавьяат эмч, спортын мастер

Б.Баярсайхан- Биеийн тамир спортын газрын дарга

Н.Баатар-Очир-Боловсрол соёлын газрын дарга

Ц.Гансүх-Мөрөн сумын Засаг дарга

Д.Цогтоо-Үндэсний лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал

Ч.Дашбаяр- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга

М.Бат-Эрдэнэ-"Нутгийн аваргууд" спортын сургуулийн захирал

Н.Сэржмятав-ХДТ-ийн дарга

Ж.Баттогтох-Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлыг орлон гүйцэтгэгч


Х.Ган-Очир-Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга

Нарийн бичгийн дарга: Б.Ганчимэг-БТСГ-ын арга зүйч

3. Улсын аварга шалгаруулах тэмцээнд шаардагдах 3000000 /Гурван сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй.

4. Улсын аварга шалгаруулах спорт аэробикийн тэмцээнийг бэлтгэл зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулж, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж тайлагнахыг Комиссын дарга /Ж.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР